

САНГИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 217 / А-161

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дах заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Төслийн санхүүжилт, зохицуулалтын газар (Т.Доржханд), Төрийн сангийн газар (Х.Пүрэвсүрэн), Монголбанкны Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Б.Батцэцэг), Монголбанкны Дотоод Хяналт, Үйл Ажиллагааны Эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.



Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн
2012 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн
212/А-161 тоот хамтарсан тушаалын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, АРИЛЖААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8.1.10 дах заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17.2 дах заалтын дагуу Монголбанк Засгийн газраас гаргасан үнэт цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулахад үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дараах байдлаар ойлгоно:
- 1.2.1 **“Засгийн газрын үнэт цаас”** (цаашид ЗГҮЦ гэх) гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан Засгийн газрын богино хугацаат үнэт цаас, Засгийн газрын бондыг хэлнэ.
- 1.2.2 **“Засгийн газрын богино хугацаат үнэт цаас”** (цаашид ЗГБХҮЦ гэх) гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичгийг хэлнэ. ЗГБХҮЦ-ыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр хямдруулсан үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө.
- 1.2.3 **“Засгийн газрын бонд”** гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш хугацаатай өрийн бичгийг хэлнэ. Засгийн газрын бондыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр арилжаагаар тогтсон үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө. Засгийн газрын бонд нь дуусах хугацаа хүртэл хагас жил тутам төлөгдөх купонтой байна.
- 1.2.4 **“Үнэт цаас гаргагч”** гэж Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хэлнэ.
- 1.2.5 **“Зуучлан борлуулагч”** гэж Монголбанкийг хэлнэ.
- 1.2.6 **“Шууд оролцогч”** гэж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй, өөрийн болон шууд бус оролцогчийн нэрийн өмнөөс ЗГҮЦ-ыг худалдан авах, худалдах банкныг хэлнэ.
- 1.2.7 **“Шууд бус оролцогч”** гэж шууд оролцогчоор дамжуулан ЗГҮЦ-ыг худалдан авах, худалдах иргэн, банкнаас бусад хуулийн этгээдийг хэлнэ.
- 1.2.8 **“Бүртгэгч”** гэж анхдагч болон хоёрдогч зах дээр ЗГҮЦ худалдан авсан этгээдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд үнэт цаасны бүртгэлийг хөтөлж, бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэх Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (цаашид ҮЦТТХТ гэх)-ийг хэлнэ.

- 1.2.9 “Цахим арилжааны систем”** гэж үнэт цаас гаргагч, зуучлан борлуулагч, бүртгэгч, шууд оролцогчдыг холбосон ЗГҮЦ-ны арилжааг явуулах цахим системийг хэлнэ.
- 1.2.10 “ЗГҮЦ-ны арилжааны хуанли”** гэж ЗГҮЦ-ны арилжааны товыг урьдчилан зарласан хуваарь (1 дүгээр хавсралт)-ийг хэлнэ.
- 1.2.11 “Арилжааны мэдэгдэл”** гэж ЗГҮЦ-ны арилжааны нөхцлийг тусгасан жагсаалт бүхий олон нийтэд зарлах мэдэгдэл (2, 3 дугаар хавсралт)-ийг хэлнэ.
- 1.2.12 “ЗГҮЦ-ны арилжаа”** гэж шууд оролцогчийн ЗГҮЦ худалдан авахаар ирүүлсэн саналыг зуучлан борлуулагч биелүүлэх замаар ЗГҮЦ-ыг худалдах үйл ажиллагааг хэлнэ.
- 1.2.13 “Өрсөлдөөнт бус санал”** гэж ялгавартай үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, нэгдсэн үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр тус тус биелэх саналыг хэлнэ.
- 1.2.14 “Ялгавартай үнэтэй арилжааны хэлбэр”** гэж шууд оролцогчийн өрсөлдөөнт бус санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, өрсөлдөөнт санал нь тухайн шууд оролцогчийн ирүүлсэн хүүний саналаар биелэх арилжааг хэлнэ.
- 1.2.15 “Нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр”** гэж шууд оролцогчийн өрсөлдөөнт бус болон өрсөлдөөнт санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр биелэх арилжааг хэлнэ.
- 1.2.16 “Арилжааг дахин нээх”** гэж үнэт цаас гаргагч өмнө арилжаалсан үнэт цаастай ижил нөхцлөөр нэмэлт үнэт цаас гаргах арилжааг хэлнэ.
- 1.2.17 “Хуримтлагдсан хүү”** гэж тодорхой үнэт цаасны арилжааг дахин нээх үед эсхүл үнэт цаасны хоёрдогч захын арилжааны үед ЗГҮЦ-ны хүү хуримтлуулж эхлэх өдөр болон төлбөр тооцооны өдрийн хооронд хуримтлагдсан хүүг хэлнэ.
- 1.2.18 “Оролцоог хязгаарлах”** гэж нэг оролцогчийн ЗГҮЦ худалдан авах саналын хэмжээг нийт гаргасан үнэт цаасны хэмжээний тодорхой хувиар тогтоож хязгаарлахыг хэлнэ.
- 1.2.19 “Хүү хуримтлуулж эхлэх өдөр”** гэж ЗГҮЦ-нд хүү хуримтлуулж эхлэх өдрийг хэлнэ. Хэрэв төлбөр тооцоо хийх өдөр арилжаа явагдсан өдрөөс хойш бол үнэт цаасны төлбөр тооцоо хийх өдрөөс эхлэн ЗГҮЦ-ны хүүг хуримтлуулна.
- 1.2.20 “Төлбөр тооцооны өдөр”** гэж ЗГҮЦ-ны арилжаагаар худалдан авсан үнэт цаасны төлбөрийг төлөх өдрийг хэлнэ.

1.3 ЗГҮЦ-ны үнэ нь үндэсний мөнгөн тэмдэгт буюу төгрөгөөр илэрхийлэгдэх бөгөөд ЗГҮЦ нь ҮЦТТТХТ-д биет бус хэлбэрээр бүртгэлтэй байна.

1.4 Нэгж ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 1,000,000 төгрөг байна.

Хоёр. Арилжаанд оролцогч талууд

Үнэт цаас гаргагч

2.1 Үнэт цаас гаргагч арилжаагаар зарах үнэт цаасны хэмжээг тухай бүр тогтооно.

2.2 Үнэт цаас гаргагч нь:

- 2.2.1 ЗГҮЦ-ны арилжааны хуанлийг бэлтгэж мэдээлнэ;
- 2.2.2 Цахим арилжааны системд ажиллах нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.2.3 Үнэт цаас гаргах бүрд арилжааны мэдэгдлийг бэлтгэнэ;
- 2.2.4 Засгийн газрын бондын купоны хэмжээг тогтооно;
- 2.2.5 Арилжааны үр дүнг олон нийтэд мэдээлнэ;
- 2.2.6 ЗГҮЦ-ны төлбөр тооцоонд хяналт тавина;
- 2.2.7 Хугацаа нь дууссан ЗГҮЦ-ны үндсэн төлбөрийг төлнө;
- 2.2.8 Засгийн газрын бондын купоны төлбөрийг төлнө;
- 2.2.9 ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжааны талаархи мэдээллийг Монголбанк, ҮЦТТТХТ-өөс авна.

2.3 Үнэт цаас гаргагч нь өөрийн цахим хуудас, Монголбанкны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ЗГҮЦ-ны арилжааны хуанлийг хагас жилээр бэлтгэн тухайн оны 1 дүгээр сарын 31, 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2.4 Үнэт цаас гаргагч нь арилжааны үр дүнг өөрийн цахим хуудас, Монголбанкны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүр нийтэд мэдээлнэ.

Зуучлан борлуулагч

2.5 ЗГҮЦ-ны арилжааны үйл ажиллагааг үнэт цаас гаргагч, Монголбанк хамтран зохион байгуулна.

2.6 ЗГҮЦ-ын арилжаатай холбоотойгоор Монголбанк нь:

- 2.6.1 ЗГҮЦ-ны арилжааг явуулах цахим системээр хангана;
- 2.6.2 ЗГҮЦ-ны арилжааг зохион байгуулна;
- 2.6.3 Үнэт цаас гаргагчид үнэт цаасны арилжаалах хэмжээ, хүүний талаар зөвлөж болно;
- 2.6.4 Үнэт цаасны арилжааны үр дүнг ҮЦТТТХТ-д хүргүүлнэ;
- 2.6.5 Шууд оролцогч болон ҮЦТТТХТ-өөс үнэт цаас эзэмшигчийн талаархи мэдээлэл, судалгааг авна;
- 2.6.6 ЗГҮЦ-ны арилжааны анхдагч зах зээлийн хандлагын талаар судалгаа гаргаж үнэт цаас гаргагчийг зах зээлийн мэдээллээр хангана;

- 2.6.7 ЗГҮЦ-ны хоёрдогч захын байдал, шууд оролцогчийн зах зээл дээрх хандлагыг ажиглана. Шаардлагатай гэж үзвэл хоёрдогч захад оролцоно.

Шууд оролцогч

- 2.7 Шууд оролцогч цахим арилжааны системийн ЗГҮЦ-ны арилжааны хэсэгт холбогдсон байх бөгөөд ҮЦТТТХТ-ийн төвлөрсөн хадгаламжид данстай байна.

- 2.8 Шууд оролцогч ЗГҮЦ-ны арилжаатай холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.8.1 ЗГҮЦ-ны арилжааны мэдэгдлийг шууд бус оролцогчид мэдээлнэ;
- 2.8.2 Анхдагч захаас ЗГҮЦ-ыг шууд худалдан авч, хоёрдогч зах дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулна;
- 2.8.3 Мөнгөний захын оролцогчдын хоорондын итгэлцлийг хадгална;
- 2.8.4 Шууд бус оролцогчоос ЗГҮЦ худалдан авах саналыг хүлээн авч арилжаанд оруулна;
- 2.8.5 Урьдчилан зарласан мэдэгдлийн дагуу ЗГҮЦ худалдан авах саналаа Монголбанкинд хүргүүлнэ;
- 2.8.6 Арилжааны үр дүнг шууд бус оролцогчид мэдээлнэ;
- 2.8.7 Шууд бус оролцогчийн худалдан авсан үнэт цаасны талаар Монголбанкинд мэдээлнэ. Мөн хоёр талын харилцан тохиролцсон бусад мэдээллийг Монголбанкинд ирүүлнэ;
- 2.8.8 Худалдан авсан ЗГҮЦ-ны төлбөрийг үнэт цаас гаргагчийн дансанд шилжүүлнэ;
- 2.8.9 Худалдан авсан ЗГҮЦ-ны төлбөрийг Монголбанк дахь харилцах данснаасаа төлөх зөвшөөрлийг Монголбанкинд ирүүлнэ.

Шууд бус оролцогч

- 2.9 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаанд шууд оролцогчоор дамжуулан оролцоно.
- 2.10 Шууд болон шууд бус оролцогч нь Монголбанкнаас гаргасан үлгэрчилсэн гэрээний дагуу ЗГҮЦ-ны арилжаанд оролцох харилцааг зохицуулна.
- 2.11 Шууд бус оролцогч нь ҮЦТТТХТ-ийн төвлөрсөн хадгаламжид данстай байна.

Гурав. ЗГҮЦ-ны арилжааг зохион байгуулах

Арилжааны ерөнхий зарчим

- 3.1 ЗГҮЦ-ны борлуулалтаар төвлөрсөн мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагч захиран зарцуулна.
- 3.2 ЗГҮЦ-ны анхны борлуулалт дуудлага худалдааны хэлбэрээр, цахим арилжааны системээр хийгдэх бөгөөд ЗГҮЦ худалдан авсан эзэмшигчийг ҮЦТТТХТ-д бүртгэснээр дуусгавар болно.
- 3.3 Үнэт цаас гаргагч, шууд оролцогчдын цахим арилжааны систем рүү нэвтрэх үйлдлийг Монголбанк хянана. Зөвхөн бүртгүүлсэн хэрэглэгчийн нэр, нууц үгээр системд нэвтэрнэ.

3.4 ЗГҮЦ-ны арилжааг урьдчилан зарласан арилжааны хуанлийн дагуу товлосон өдөр явуулна.

3.5 Үнэт цаас гаргагч нь ЗГБХҮЦ-ны арилжааны мэдэгдлийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу, Засгийн газрын бондын арилжааны мэдэгдлийг 3 дугаар хавсралтын дагуу тус тус гаргана.

3.6 Үнэт цаас гаргагч нь арилжааны өдрөөс ажлын 3 өдрийн өмнөх өдрийн 14:00 цагаас өмнө ЗГҮЦ-ны арилжааны мэдэгдлийг цахим арилжааны системээр дамжуулан Монголбанкинд ирүүлнэ. Хэрэв цахим арилжааны системээр ирүүлэх боломжгүй тохиолдолд арилжааны мэдэгдлийг факсаар, цахим шуудангаар эсхүл биечлэн ирүүлнэ. Энэ тохиолдолд Монголбанк арилжааны мэдэгдлийг хүлээн авсан эсэхээ эргэн мэдэгдэнэ.

3.7 Монголбанк мөн өдрийн 14:30 цагт ЗГҮЦ-ны арилжааны мэдэгдлийг цахим арилжааны системээр дамжуулан шууд оролцогчдод хүргүүлнэ. Хэрэв цахим арилжааны системээр хүргүүлэх боломжгүй тохиолдолд тухайн өдрийн 16:30 цагаас өмнө арилжааны мэдэгдлийг факсаар эсхүл цахим шуудангаар шууд оролцогчдод хүргүүлнэ. Энэ тохиолдолд шууд оролцогч арилжааны мэдэгдлийг хүлээн авсан эсэхээ эргэн мэдэгдэнэ.

3.8 Шууд оролцогч нь шууд бус оролцогчдод ЗГҮЦ-ны арилжааны мэдэгдлийг биечлэн, утсаар, албан бичгээр эсхүл цахим шуудангаар тухайн өдөрт багтаан хүргүүлнэ.

3.9 ЗГҮЦ-ны эргэн төлөгдөх өдөр нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр таарч байвал уг өдрийн өмнөх ажлын өдөр төлөгдөхөөр арилжааг зарлана.

Арилжааны санал

3.10 Шууд оролцогч өөрийн санал болон шууд бус оролцогч бүрийн үнэт цаас худалдан авах саналыг тусад нь арилжааны мэдэгдэлд дурьдсан цагт багтаан цахим арилжааны системээр дамжуулан Монголбанкинд ирүүлнэ. Хэрэв шууд болон шууд бус оролцогч хүүгээрээ ялгаатай олон санал ирүүлсэн бол ялгаатай хүү тус бүрээр тусад нь санал ирүүлнэ.

3.11 Шууд оролцогч нь зөвхөн өрсөлдөөнт санал ирүүлэх бөгөөд хүүгээрээ ялгаатай хэд хэдэн санал ирүүлж болно. Шууд бус оролцогч нь өрсөлдөөнт бус нэг санал, өрсөлдөөнт хэд хэдэн санал ирүүлж болно.

3.12 Шууд оролцогчийн өөрийн болон шууд бус оролцогчийн өмнөөс анхдагч захаас худалдан авах үнэт цаасны хэмжээ нь тухайн хагас жилд гаргасан нийт ЗГҮЦ-ны нэрлэсэн үнийн 3-аас доошгүй хувь байна. Энэхүү заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд шууд оролцогчоос хасна.

3.13 Шууд оролцогч ЗГҮЦ-ны хүү (өгөөж)-ний саналыг мянгатын нарийвчлалаар ирүүлнэ.

- 3.14 Шууд оролцогч нь шууд бус оролцогчоос ирүүлсэн ЗГҮЦ худалдан авах саналыг хадгална.
- 3.15 Шууд оролцогч нь шууд бус оролцогчийн ирүүлсэн саналын эх хувийг үнэт цаас гаргагч болон Монголбанк шаардсан тохиолдолд ирүүлнэ.
- 3.16 Шууд оролцогч техникийн саатлаас шалтгаалж цахим арилжааны системээр үнэт цаас худалдан авах саналаа ирүүлэх боломжгүй тохиолдолд арилжааны цаг дуусахаас өмнө энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу үнэт цаас худалдан авах саналаа факсаар эсхүл биечлэн ирүүлж болно. Энэ тохиолдолд үнэт цаас гаргагч болон Монголбанкинд утсаар урьдчилан мэдэгдсэн байх шаардлагатай.
- 3.17 Шууд оролцогч нь мэдэгдэлд заасан арилжааны санал хүлээж авах цаг дуусаагүй тохиолдолд саналаа өөрчилж эсхүл хүчингүй болгож болно.
- 3.18 Мэдэгдэлд заасан арилжааны цаг дууссан тохиолдолд шууд оролцогч нь ирүүлсэн саналаа өөрчлөх эсхүл хүчингүй болгох эрхгүй.
- 3.19 Үнэт цаас гаргагч болон Монголбанк цахим арилжааны системээс тухайн арилжааны санал оруулах хугацаа дуустал шууд оролцогчдын саналыг харах боломжгүй байна. Харин шууд оролцогч нь арилжааны туршид бусад шууд оролцогчийн саналыг харах боломжгүй байна.
- 3.20 Монголбанк болон үнэт цаас гаргагч нь арилжааны саналын талаархи мэдээллийн нууцыг хадгална.
- 3.21 Шууд оролцогч нь шууд бус оролцогчийн үнэт цаас худалдан авах саналын талаархи мэдээллийн нууцыг хадгална.

Арилжааны санал хуваарилалт

- 3.22 Монголбанк ЗГҮЦ-ны хуваарилалтыг арилжааны мэдэгдэлд заасны дагуу нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр эсхүл ялгавартай үнэтэй арилжааны хэлбэрийн аль нэгээр хуваарилна.
- 3.23 ЗГҮЦ-ны хуваарилалтад дараах хязгаарлалтыг хэрэглэж болох бөгөөд аливаа хуваарилалтын хязгаарлалтыг арилжааны мэдэгдэлд тусгасан байна:
- 3.23.1 Нийт гаргасан багцын 15-аас илүүгүй хувийг өрсөлдөөнт бус саналд хуваарилна;
 - 3.23.2 Шууд оролцогчид өрсөлдөөнт бус санал хуваарилахгүй;
 - 3.23.3 Нэг шууд оролцогчид нийт гаргасан багцын 50-иас илүүгүй хувийг хуваарилна. Үнэт цаас гаргагч энэхүү хязгаарлалтыг тухайн нэг арилжааны хувьд өөрчлөх тохиолдолд арилжаа зарлах үед Монголбанкинд мэдэгдэнэ;
 - 3.23.4 Нэг шууд бус оролцогчид нийт гаргасан багцын 50-иас илүүгүй хувийг хуваарилна. Үнэт цаас гаргагч энэхүү хязгаарлалтыг тухайн нэг арилжааны хувьд өөрчлөх тохиолдолд арилжаа зарлах үед Монголбанкинд мэдэгдэнэ.

3.24 Монголбанк шууд оролцогчоос ирүүлсэн саналыг дараах зарчмаар хуваарилна:

3.24.1 ЗГҮЦ худалдан авах өрсөлдөөнт бус саналыг өрсөлдөөнт саналаас түрүүлж хангана.

3.24.2 Шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт бус саналын нийт хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй бол хуваарилалтыг шууд оролцогчийн ирүүлсэн саналаар хийнэ. Шууд оролцогчийн ирүүлсэн өрсөлдөөнт бус санал нь тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилах буюу энэ журмын 3.24.8-д заасан томъёог ашиглан хуваарилалтыг хийнэ.

3.24.3 Энэ журмын 3.24.2-т заасны дагуу хуваарилалт хийсний дараа шууд оролцогчдоос ирүүлсэн өрсөлдөөнт саналыг хүү (өгөөжийн хувь)-ний өсөх дарааллаар жагсаан, хамгийн бага хүүний саналаас эхэлж хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн шууд оролцогч ижил хүүний санал ирүүлсэн бөгөөд нийт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд энэ журмын 3.24.8-д заасан зарчмаар хуваарилалтыг хийнэ.

3.24.4 Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага тохиолдолд өрсөлдөөнт бус саналд хуваарилах хэмжээг өсгөж болох бөгөөд ингэхдээ өрсөлдөөнт бус санал болон өрсөлдөөнт саналын нийт хэмжээ нь гаргасан багцын хэмжээнээс хэтрэхгүй байна.

3.24.5 Өрсөлдөөнт бус саналын хэмжээ өрсөлдөөнт бус саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс бага, өрсөлдөөнт саналын хэмжээ өрсөлдөөнт саналд хуваарилахаар тогтоосон хэмжээнээс их тохиолдолд өрсөлдөөнт саналд хуваарилах хэмжээг өсгөж болох бөгөөд ингэхдээ өрсөлдөөнт бус санал болон өрсөлдөөнт саналын нийт хэмжээ нь гаргасан багцын хэмжээнээс хэтрэхгүй байна.

3.24.6 Ялгавартай үнэтэй арилжааны үед өрсөлдөөнт бус саналын хүү нь амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүтэй тэнцүү байна. Өрсөлдөөнт саналын хүү нь тухайн шууд оролцогчоос ирүүлсэн хүүний санал байна.

3.24.7 Нэгдсэн үнэтэй арилжааны үед өрсөлдөөнт бус болон өрсөлдөөнт саналын хүү нь амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын хамгийн өндөр хүү (таслагдсан хүү)-тэй тэнцүү байна.

3.24.8 ЗГҮЦ-ны арилжааны хувь тэнцүүлэн хийх хуваарилалтыг дараах томъёогоор тооцно:

$$P = B * \frac{V2}{V1}$$

P - Тухайн шууд оролцогчид хуваарилах хэмжээ

V1 - Шууд оролцогчдын ирүүлсэн нийт саналын хэмжээ

V2 - Тухайн шууд оролцогчийн ирүүлсэн саналын хэмжээ

B - Зарласан нийт хэмжээ

3.24.9 Хувь тэнцүүлэн хуваарилалт хийхэд математикийн бүхэлчлэх аргачлалыг хэрэглэж таслалын ард оронгийн нарийвчлалгүй бүхэл хувиар тооцно.

- 3.25 ЗГҮЦ-ны арилжааны хуваарилалтын дараа борлогдоогүй үлдсэн хэсгийг Монголбанк худалдан авахгүй.

Санал цуцлах

- 3.26 Үнэт цаас гаргагч, Монголбанк арилжаанд шууд оролцогчийг үгсэн тохиролцсон эсхүл үндэслэлгүй өндөр хүүний санал ирүүлсэн гэж үзвэл уг саналыг цуцлах эрхтэй. Санал цуцалсан талаар тайлбарлахгүй. Үнэт цаас гаргагч болон Монголбанк зах зээлийн зарчим, шударга ёсыг баримтлана.
- 3.27 Санал цуцалсантай холбогдуулж үнэт цаас гаргагч нь тухайн мэдэгдэлд зааснаас бага хэмжээний үнэт цаас арилжаалж болно.

Арилжаа цуцлах

- 3.28 Арилжааг эрчим хүчний түр саатал, програм хангамжийн гэмтэл эсхүл давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цуцалж болно.
- 3.29 Арилжааг цуцалсан тохиолдолд үнэт цаас гаргагч Монголбанкаар дамжуулан шууд оролцогчид дараагийн арилжаа явагдах огноо, цагийг мэдэгдэнэ.

Арилжааны үр дүн

- 3.30 Арилжааны санал хүлээн авах цаг дууссаны дараа Монголбанк арилжааны үр дүнг үнэт цаас гаргагчид мэдэгдэнэ.
- 3.31 Арилжааны үр дүн нь биелсэн болон биелээгүй саналыг багтаасан байна.
- 3.32 Монголбанк арилжаа явагдаж дуусмагц арилжааны үр дүнг цахим арилжааны системээр дамжуулан шууд оролцогчид мэдэгдэнэ.
- 3.33 Шууд оролцогч нь өөрийн саналын үр дүн болон нийтэд мэдээлэх арилжааны үр дүнг цахим арилжааны системээс харна.
- 3.34 Нийтэд мэдээлэх арилжааны үр дүн нь нийт зарласан хэмжээ, арилжаанд ирсэн нийт саналын хэмжээ, биелсэн саналын хэмжээ, арилжааны жигнэсэн дундаж хүү, биелсэн саналын хамгийн өндөр хүү, хамгийн бага хүү, таслагдсан хүү зэргийг тусгасан байна.
- 3.35 Шууд оролцогч нь цахим арилжааны системээр арилжааны үр дүнг хүлээн авсны дараа тухайн ажлын өдөрт багтаан шууд бус оролцогчид өөрийнх нь болон арилжааны нийт үр дүнг мэдээлнэ.
- 3.36 Арилжааны үр дүнг үнэт цаас гаргагч болон Монголбанкны цахим хуудсаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

Арилжааг дахин нээх

- 3.37 Үнэт цаас гаргагч хугацаа нь дуусаагүй байгаа үнэт цаасны өмнө хийгдсэн арилжааг дахин нээж болох ба ингэсэн тохиолдолд цахим арилжааны системээр Монголбанкинд мэдэгдэнэ.

3.38 Монголбанк арилжааг дахин нээснийг шууд оролцогчдод цахим арилжааны системээр, факсаар эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ. Шууд оролцогч нь шууд бус оролцогчдод арилжаа дахин нээснийг биечлэн, утсаар, албан бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.

3.39 Дахин нээсэн арилжааны купоны хувь хэмжээ нь анхны арилжаагаар тогтсон купоны хувь хэмжээтэй тэнцүү байна.

Ээлжит бус арилжаа

3.40 Үнэт цаас гаргагч нь ЗГҮЦ-ны ээлжит бус арилжааг Монголбанкинд мэдэгдэн явуулж болно. Ээлжит бус арилжаа нь ээлжит арилжаатай ижил бөгөөд зөвхөн арилжааны хуанлид ороогүйгээрээ ялгаатай.

3.41 Үнэт цаас гаргагч болон Монголбанк ээлжит бус арилжааны мэдэгдлийг шууд оролцогчдод цахим арилжааны системээр, факсаар эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ. Шууд оролцогч нь шууд бус оролцогчдод ээлжит бус арилжааны мэдэгдлийг биечлэн, утсаар, албан бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэнэ.

Дөрөв. Үнэ, купон

4.1 ЗГБХҮЦ-ны өгөөж, үнийг дараах томъёогоор тооцно:

ЗГБХҮЦ-ны өгөөжийг дараах томъёогоор тооцно:

$$i = \frac{F}{P} \cdot \frac{P}{t} \cdot \frac{360}{t}$$

ЗГБХҮЦ-ны өгөөжид суурилсан хямдруулсан үнийг дараах томъёогоор тооцно:

$$P = \frac{F}{\left[1 + i \cdot \left(\frac{t}{360}\right)\right]}$$

i = Үнэт цаасны өгөөжийн хувь, жилээр

t = Үнэт цаасны хугацаа

F = Үнэт цаасны нэрлэсэн үнэ

P = Үнэт цаасны хямдруулсан үнэ

4.2 Засгийн газрын бондын үнийг дараах томъёогоор тооцно:

$$P_{bond} = \sum_{t=1}^m \frac{(P_{par} \cdot i_c / n)}{(1 + YTM/n)^t} + \frac{P_{par}}{(1 + YTM/n)^m}$$

P_{bond} – бондын үнэ
 P_{par} – бондын нэрлэсэн үнэ
 i_c – купоны хувь
 n – купоны төлбөр хийх тоо (давтамж)
 m – төлөгдөх өдөр хүртлэх хугацаа
 YTM – бонд төлөгдөх хугацаа хүртлэх тогтмол өгөөж

4.3 Засгийн газрын бондын купоныг бодит/360 хоногт үндэслэн тооцно.

4.4 Хуримтлагдсан хүүг дараах томъёогоор тооцно:

$$AI = P_{par} * \frac{I}{360} * (DD - SD)$$

AI – Хуримтлагдсан хүү

P_{par} – Бондын нэрлэсэн үнэ

I – Купоны хувь

SD – Төлбөр тооцооны өдөр

DD – Хүү хуримтлуулж эхлэх өдөр

4.5 Арилжааны мэдэгдэлд купоны хувийг заагаагүй тохиолдолд ялгавартай үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж утгатай хамгийн ойр байхаар бууруулж 1/8 алхамаар тогтооно. Нэгдсэн үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн саналын таслагдсан утгатай хамгийн ойр байхаар бууруулж 1/8 алхамаар тогтооно.

Тав. ЗГҮЦ-ны бүртгэл

5.1 Шууд оролцогчийн худалдан авсан ЗГҮЦ-ны мэдээлэл цахим арилжааны системд автоматаар бүртгэгдэнэ.

5.2 Бүртгэгч нь ISIN буюу үнэт цаасны олон улсын бүртгэлийн дугаарыг ЗГҮЦ-ыг төрөл тус бүрээр өгч төвлөрсөн хадгаламжинд бүртгэнэ.

5.3 Шууд оролцогч нь арилжаа болсон өдрийн эцэст үнэт цаас худалдан авсан шууд бус оролцогчийн мэдээллийг цахим арилжааны системээр ирүүлнэ. Мэдээлэл нь дараах бүрдүүлбэртэй байна:

- 5.3.1 Хуулийн этгээдийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, хувь хүн ЗГҮЦ худалдан авсан бол регистерийн дугаар;
- 5.3.2 Хуулийн этгээд бол түүний нэр, хувь хүн бол ургийн овог, овог, нэр;
- 5.3.3 Хаяг;
- 5.3.4 Хуулийн этгээд бол төв байрны хаяг, хувь хүн бол гэрийн хаяг;
- 5.3.5 Банкин дахь дансны дугаар;
- 5.3.6 ҮЦТТТХТ дэх дансны дугаар;
- 5.3.7 Худалдан авсан ЗГҮЦ-ны тоо ширхэг;
- 5.3.8 Үнэ/өгөөж.

5.4 Шууд оролцогч нь арилжааны өдрийн эцэст энэ журмын 5.3-т заасан шууд бус оролцогчийн мэдээллийг оруулаагүй тохиолдолд үнэт цаасны төлбөрийг төлөх үүрэгтэй тухайн шууд оролцогчид үнэт цаасыг шилжүүлнэ.

5.5 Техникийн саатлаас шалтгаалан шууд оролцогч нь шууд бус оролцогчийн мэдээллийг оруулаагүй тохиолдолд 5.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхгүй. Энэ тохиолдолд шууд оролцогч нь арилжаа явагдсан өдрийн дараагийн ажлын өдрийн 9:00 цагаас өмнө уг мэдээллийг оруулсан байна.

5.6 Үнэт цаас гаргагч нь цахим арилжааны системээр дамжуулан үнэт цаасны төлбөр төлсөн эзэмшигчийн мэдээллийг ҮЦТТХТ-д илгээхийг Монголбанкинд зөвшөөрнө.

5.7 Монголбанк үнэт цаасны төлбөр төлсөн эзэмшигчийн мэдээллийг ҮЦТТХТ-д цахим системээр илгээнэ. ҮЦТТХТ нь анхдагч захын арилжааны мэдээллийг үндэслэн үнэт цаасны эзэмшигчийн бүртгэлийг хөтөлнө.

5.8 ҮЦТТХТ нь үнэт цаасны эзэмшигч өөрчлөгдөх тухай бүр Монголбанкинд цахим арилжааны системээр мэдэгдэнэ.

5.9 ҮЦТТХТ нь Засгийн газрын бондын нэрлэсэн үнэ, купоны төлбөр төлөгдөх өдрөөс ажлын нэг өдрийн өмнө Засгийн газрын бонд эзэмшигчийн өмчлөлд аливаа өөрчлөлт хийхгүй.

Зургаа. Үнэт цаасны төлбөр тооцоо

6.1 Шууд оролцогч нь худалдан авсан үнэт цаасны төлбөрийг арилжааны өдрөөс хойш ажлын 3 өдрийн дараа (Т+3) үнэт цаас гаргагчийн дансанд шилжүүлнэ.

6.2 Шууд оролцогч нь өөрийн болон шууд бус оролцогчийн өмнөөс худалдан авсан үнэт цаасны төлбөрийг тусад нь гүйцэтгэнэ.

6.3 Үнэт цаас гаргагч болон Монголбанк үнэт цаасны төлбөр төлсөн эсэхийг хянана.

6.4 Шууд оролцогч нь төлбөр хийх эцсийн өдөр үнэт цаасны төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд Монголбанк үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс шууд оролцогчийн харилцах данснаас төлбөрийг суутгаж төлүүлнэ.

6.5 Шууд оролцогч арилжаанд амжилттай оролцож үнэт цаас худалдан авсан боловч үнэт цаасны төлбөрийг төлөөгүй тохиолдолд ЗГҮЦ-ны дараагийн арилжаануудад оролцохыг хязгаарлана.

6.6 Шууд оролцогч нь худалдан авсан үнэт цаасны төлбөрөөс илүү төлбөр шилжүүлсэн тохиолдолд үнэт цаас гаргагч илүү шилжүүлсэн төлбөрийг төлбөр хийсэн өдөрт багтаан шууд оролцогчид буцаан шилжүүлнэ.

6.7 Үнэт цаас гаргагч үнэт цаасны купоны төлбөрийг купон төлөх өдрийн 13:00 цагаас өмнө Монголбанк дахь ҮЦТТХТ-ийн дансанд шилжүүлж, ҮЦТТХТ тухайн өдөрт багтаан үнэт цаас эзэмшигчид төлнө.


- 6.8 Үнэт цаас гаргагч үнэт цаасны нэрлэсэн үнэ, купоны төлбөрийг үнэт цаасны хугацаа дуусах өдрийн 10:00 цагаас өмнө Монголбанкн дахь ҮЦТТТХТ-ийн дансанд шилжүүлж, ҮЦТТТХТ тухайн өдөрт багтаан үнэт цаасны эцсийн эзэмшигчид төлнө.
- 6.9 Үнэт цаас эзэмшигч ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ, купоны төлбөрийг хүлээн авах банкны дансны дугаарыг өмнө мэдэгдсэнээс өөрчлөх тохиолдолд уг үнэт цаасны хугацаа дуусахаас ажлын 2 өдрийн өмнө ҮЦТТТХТ-д албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.10 Шууд оролцогч ҮЦТТТХТ-д дансны дугаараа буруу оруулах, эсхүл огт оруулаагүйгээс шалтгаалан төлбөр төлөгдөөгүй тохиолдолд үнэт цаас гаргагч зөв дансыг хүлээн автал төлбөрийг хийхгүй.
- 6.11 Үнэт цаас гаргагч үнэт цаасны нэрлэсэн үнэ, купоны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгээс 0.1 хувийн алданги тооцож үнэт цаас эзэмшигчид төлнө.

Долоо. Бусад

- 7.1 Засгийн газар ЗГҮЦ-ыг зөвхөн Монголбанкаар дамжуулан арилжаална.
- 7.2 Монголбанк ЗГҮЦ-ыг зуучлан борлуулсны шимтгэл үнэт цаас гаргагчаас авахгүй.
- 7.3 ЗГҮЦ-ны арилжаанд үнэт цаас гаргагч хяналт тавьж ажиллана.
- 7.4 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

20.. оны ... сарын ... өдөр


Арилжааны хуанли



Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны арилжааны хуанли			
Үнэт цаасны төрөл, хугацаа	Зарлах өдөр	Арилжааны өдөр	Төлбөр тооцооны өдөр

20.. оны ... сарын ... өдөр


ЗГБХҮЦ-ны арилжааны мэдэгдэл




Үнэт цаасны төрөл, хугацаа	
Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг	
Ижил үнэт цаасны үлдэгдэл	
Олон улсын үнэт цаасны бүртгэлийн дугаар (ISIN)	
Арилжаа явагдах огноо	
Төлбөр тооцоо хийх огноо	
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	
Үнэт цаасны өгөөжийн хувь	Арилжаагаар тодорхойлогдоно.
Арилжааны хэлбэр (ялгавартай үнэтэй эсхүл нэгдсэн үнэтэй арилжаа)	
Өрсөлдөөнт бус санал хүлээж авах цаг	
Өрсөлдөөнт санал хүлээн авах цаг	
Өрсөлдөөнт бус нийт саналд хуваарилах дээд хэмжээ	
Нэг шууд бус оролцогчийн өрсөлдөөнт бус саналд хуваарилах дээд хэмжээ	
Шууд болон шууд бус оролцогчдод хуваарилах өрсөлдөөнт саналын дээд хэмжээ	
Монголбанкин дахь үнэт цаас гаргагчийн дансны мэдээлэл	

20.. оны ... сарын ... өдөр

Засгийн газрын бондын арилжааны мэдэгдэл



Бондын төрөл, хугацаа	УХИ0014
Арилжаалах бондын тоо ширхэг	
Ижил бондын үлдэгдэл	
Олон улсын үнэт цаасны бүртгэлийн дугаар (ISIN)	
Арилжаа явагдах огноо	
Төлбөр тооцоо хийх огноо	
Бондын хугацаа дуусах огноо	
Бондын өгөөжийн хувь	Арилжаагаар тодорхойлогдоно.
Купоны хувь хэмжээ	
Купон төлөх давтамж, купон төлөх огноо	
Арилжааны хэлбэр (ялгавартай үнэтэй эсхүл нэгдсэн үнэтэй арилжаа)	
Өрсөлдөөнт бус санал хүлээж авах цаг	
Өрсөлдөөнт санал хүлээн авах цаг	
Өрсөлдөөнт бус нийт саналд хуваарилах дээд хэмжээ	
Нэг шууд бус оролцогчийн өрсөлдөөнт бус саналд хуваарилах дээд хэмжээ	
Шууд болон шууд бус оролцогчдод хуваарилах өрсөлдөөнт саналын дээд хэмжээ	
Монголбанкн дахь үнэт цаас гаргагчийн дансны мэдээлэл	



Үнэт цаас худалдан авах үнийн санал

Дансны дугаар:

Арилжааны дугаар:

Шууд оролцогчийн нэр:

Арилжааны огноо

Гаргах огноо

Дуусах огноо

--	--	--

Өрсөлдөөнт санал:


	Саналын хэмжээ	Өгөөж (хувь, жилээр)	Шууд/шууд бус оролцогчийн нэр
1			
2			
3			
4			

Өрсөлдөөнт бус санал:

	Саналын хэмжээ	Шууд/шууд бус оролцогчийн нэр
1		
2		
3		
4		

Санал өгсөн цаг: , огноо:

Шууд оролцогчийн гарын үсэг



ШУУД БУС ОРОЛЦОГЧ ШУУД ОРОЛЦОГЧООР ДАМЖУУЛАН ЗАСГИЙН
ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ҮЛГЭРЧИЛСЭН ГЭРЭЭ

20... оны ...сарын ...-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр Иргэний хууль, холбогдох бусад хууль, Монголбанк, Сангийн яамнаас баталсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын дагуу нэг талаас банк (Цаашид Шууд оролцогч гэх) нөгөө талаас (цаашид Шууд бус оролцогч, хамтад нь Талууд гэх) нарын харилцан тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын үнэт цаас (цаашид ЗГҮЦ гэх)-ны анхдагч захын арилжаанд оролцоход үүсэх харилцааг зохицуулна

1.2 Гэрээний талууд:

Шууд оролцогчийн нэр, албан ёсны хаяг:

.....

Шууд бус оролцогчийн нэр, албан ёсны хаяг, иргэн бол регистрийн дугаар, оршин суух хаяг:

.....

1.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Санлүүгийн зохицуулах хорооноос баталсан “Брокер, дилерийн үйл ажиллагааны журам”, бусад хууль, тогтоомжид нийцүүлэн энэхүү гэрээнд нэмэлт зохицуулалт оруулж болно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

2.1 Шууд оролцогч ЗГҮЦ-ыг дараах нөхцөлөөр Шууд бус оролцогчийн нэрийн өмнөөс худалдан авна:

2.1.1 Шууд бус оролцогч нь энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтын дагуу ЗГҮЦ худалдан авах саналаа бэлтгэж Шууд оролцогчоор дамжуулан Монголбанкны цахим арилжаанд оролцоно.

2.1.2 ЗГҮЦ худалдан авах саналыг 2 хувь үйлдэх бөгөөд Шууд оролцогч, Шууд бус оролцогч тус бүр 1 хувийг хадгална.

2.1.3 Тухайн нэг арилжаанд Шууд бус оролцогч ЗГҮЦ худалдан авах саналыг зөвхөн нэг Шууд оролцогчоор дамжуулан өгнө.

2.1.4 Шууд бус оролцогч нь анхдагч захын арилжаанаас худалдаж авсан ЗГҮЦ-ны төлбөр болон шимтгэлийг арилжаа явагдсан өдрөөс хойш ажлын 3 (Т+3) өдрийн дотор Шууд оролцогч дахь тусгай харилцах дансанд байршуулж, төлбөрийг Т+3 хугацаанд хийнэ.

- 2.1.5 ҮЦТТХТ нь Шууд бус оролцогчийн худалдан авсан ЗГҮЦ-ны эзэмших эрхийг тухайн Шууд бус оролцогчийн ҮЦТТХТ дэх үнэт цаасны дансанд Т+3 хугацаанд бүртгэнэ.
- 2.1.6 Шууд бус оролцогч ЗГҮЦ-ны өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой шимтгэлийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” (цаашид ҮЦТТХТ гэх)-ийн холбогдох журмын дагуу ҮЦТТХТ-д төлнө.

ГУРАВ. ШУУД БУС ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 3.1 Шууд бус оролцогч нь анхдагч зах дээр ЗГҮЦ худалдан авахын тулд Шууд оролцогчид дараах мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Төлбөр тооцоо хийх банкны дансны дугаар;
- 3.1.2 ҮЦТТХТ-д нээлгэсэн дансны дугаар;
- 3.1.3 Арилжаанд санал өгөх эрх бүхий этгээдийн мэдээлэл.
- 3.2 Энэ гэрээний 3.1-т заасан мэдээллүүд өөрчлөгдөх тухай бүр Шууд бус оролцогч Шууд оролцогчид бичгээр мэдэгдэнэ.
- 3.3 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаанд оролцох тухайгаа Шууд оролцогчид арилжаа явагдах өдрөөс нэгээс доошгүй хоногийн өмнө албан бичгээр, цахим шуудангаар эсвэл утсаар мэдэгдэнэ.
- 3.4 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаанд оролцох саналаа ЗГҮЦ-ны мэдэгдэлд дурьдсан мэдээлэлд үндэслэн бичгээр бэлтгэж тухайн арилжааны санал авах эцсийн хугацаа дуусахаас өмнө биечлэн, цахим шуудангаар эсвэл факсаар Шууд оролцогчид ирүүлнэ.
- 3.5 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ-ны анхдагч захын арилжааны саналын хэмжээ, хүүг өөрчлөх, цуцлах тохиолдолд арилжааны санал авах эцсийн хугацаа дуусахаас өмнө Шууд оролцогчид биечлэн эсвэл факсаар мэдэгдэнэ.
- 3.6 Арилжааны цаг дууссанаас хойш Шууд бус оролцогч нь саналаа цуцлах, өөрчлөх эрхгүй.
- 3.7 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ-ны анхдагч захын арилжааны үйл явц, шаардлагатай мэдээллийг Шууд оролцогчоос авах эрхтэй.
- 3.8 Шууд бус оролцогч нь тухайн арилжааны үр дүн болон өөрийн худалдаж авсан ЗГҮЦ-ны үр дүнг Шууд оролцогчоос гаргуулан авах эрхтэй.

ДӨРӨВ. ШУУД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 4.1 Шууд оролцогч нь арилжааны мэдээллийг цахим арилжааны системд орсон ЗГҮЦ-ны арилжааны мэдэгдэлд үндэслэн арилжаа явагдахаас ажлын 3 хоногийн өмнө Шууд бус оролцогчид хүргүүлнэ.
- 4.2 Шууд оролцогч нь Шууд бус оролцогчийн саналыг хүлээн авч Монголбанкны цахим арилжаанд оруулна.
- 4.3 Шууд оролцогч нь тухайн арилжааны үр дүн болон Шууд бус оролцогчийн саналд хуваарилагдсан ЗГҮЦ-ны үр дүнг Шууд бус оролцогчид арилжаа явагдсан өдөрт багтаан бичгээр эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.

- 4.4 Шууд бус оролцогч нь ЗГҮЦ худалдан авсан боловч үнэт цаасны төлбөрийг Т+3 хугацаанд хийгээгүй тохиолдолд Шууд оролцогч худалдаж авсан ЗГҮЦ-ыг өөрийн нэр дээр шилжүүлэн авах эрхтэй.
- 4.5 Шууд оролцогч нь Шууд бус оролцогчийн дансны болон бизнесийн нууцыг чанд хадгална.
- 4.6 Шууд оролцогч нь ЗГҮЦ худалдан авах санал цуцлагдсантай холбоотой аливаа хохирлыг Шууд бус оролцогчийн өмнө хариуцахгүй.

ТАВ. БУСАД

- 5.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно. Талууд гэрээний хугацааг харилцан тохиролцож тогтооно.
- 5.2 Талуудыг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурж буй этгээд нь Шууд болон Шууд бус оролцогчийг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээд байна. Иргэн бол эрх зүйн бүрэн чадамжтай хувь хүн байна.
- 5.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, оорчлолт оруулж болох бөгөөд тус нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.4 Энэхүү гэрээг хууль, холбогдох журамд зааснаас гадна гэрээний аль нэг тал нь гэрээгээр болон хуулиар хүлээсэн үүргээ удаа дараа, ноцтой зөрчсөн тохиолдолд хохирол хүлээсэн талын санаачилгаар цуцалж болно.
- 5.5 Энэхүү гэрээний талаархи маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.6 Энэхүү гэрээг Монгол улсын иргэн, хуулийн этгээдтэй Монгол хэл дээр, гадаадын иргэн, хуулийн этгээдтэй Монгол, Англи хэл дээр тус бүр 2 хувь бичгээр үйлдэнэ. Гэрээний орчуулгатай холбоотой үл ойлголцол, маргаан гарсан тохиолдолд Монгол хэл дээрх эх хувийг баримтлана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ШУУД ОРОЛЦОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

ШУУД БУС ОРОЛЦОГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

.....

Шууд бус оролцогч шууд оролцогчоор дамжуулан засгийн газрын
үнэт цаас худалдан авах үлгэрчилсэн гэрээний 1 дүгээр хавсралт

ЗГҮЦ худалдан авах санал

Шууд оролцогчийн нэр: Харилцах утасны дугаар

Шууд бус оролцогчийн нэр:

Дансны дугаар: РД: Харилцах утасны дугаар:
..... Хаяг:

Өрсөлдөөнт санал:

	Саналын хэмжээ (тоо ширхэг)	Өгөөж (хувь, жилээр)	Нэгжсийн үнэ
1			
2			
3			
4			

Өрсөлдөөнт бус санал:

	Саналын хэмжээ (тоо ширхэг)	Нэгжсийн үнэ
1		
2		
3		
4		

Шууд бус оролцогчийн гарын үсэг/...../

/гарын үсэг/ /овгийн эхний үсэг, нэр/

..... /хуулийн этгээд бол албан тушаа, тамга/

Шууд оролцогчийн гарын үсэг/...../

/гарын үсэг/ /овгийн эхний үсэг/

Санал өгсөн цаг: , огноо: